


# ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭ ШАЛГАХ

Та эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлсөн эсэхээ байгаа газраасаа цаг алдалгүй хялбархан шалгах боломжтой.

## ЭМД-ЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТӨӨ ШАЛГАХ АРГУУД:


- ЭМДЕГ-ын [www.emd.gov.mn/rd/search](http://www.emd.gov.mn/rd/search) сайтад регистрийн дугаараа оруулан шалгах.




- EBarimt аппликэйшнээр шалгах.



- E-Mongolia системээс шалгах.



- ЭМД-ын 1800-1363 лавлах утсанд холбогдож шалгуулах.




# ЭМД-ЫН ШИМТГЭЛЭЭ EBarimt АППЛИКЕЙШНЭЭР ТӨЛӨХ



Даатгуулагч та EBarimt аппликэйшнээр өөрийнхөө болон бусдын ЭМД-ын шимтгэлийг хялбархан төлөх боломжтой.


### Алхам 1:

Гар утасныхаа APPSTORE болон PLAYSTORE-оос ebarimt гэж хайн UPDATE хийж, нэвтрэх. Үйлчилгээ цэсээс “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” хэсгийг сонгох.




### Алхам 2:

Үйлчилгээ цэсээс Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, оюутан, тодорхой хөдөлмөр эрхлээгүй бусад иргэн хэсгийг сонгоно.




### Алхам 3:

Албан журмын даатгал сонголтоор төлөх гэдгийг сонгох.




### Алхам 4:

Үйлчилгээ авах иргэний регистрийн дугаар хэсэгт шимтгэл төлөх хүнийхээ РД-ыг оруулан ШАЛГАХ товчийг дарна.




### Алхам 5:

Ингэснээр шимтгэл төлөгдсөн сарууд НОГООН өнгөөр, төлөгдөөгүй сарууд ШАР өнгөөр ялгарч харагдана.




### Алхам 6:

Хүснэгтээс шар өнгөтэй саруудыг идэвхжүүлэн, цэнхэр болгоно.



### Алхам 7:

Та сонгосон банкныхаа аппликэйшн руу нэвтрэн ҮНИЙН ДҮН, ДАНСНЫ ДУГААР, ГҮЙЛГЭЭНИЙ УТГА ДЭЭР “2” гэсэн нэхэмжлэх автоматаар үүсдэг бөгөөд үргэлжлүүлэх товчийг дарж шилжүүлэг хийгдэнэ.



### Алхам 8:

Шимтгэлээ төлөгдсөн эсэхийг И-Баримт аппликэйшнээр Үйлчилгээ цэсийн “Төлөгдсөн” хэсгээс харах боломжтой.

